

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Хан-Уул дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс нь Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж, хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлэх зорилт, Байгалийн нөөц баялагийг нөхөн сэргээх, байгаль орчны бохирдол, доройтлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах замаар хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангуулах, ашиглалтын нөөцийг бий болгох, Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангуулах замаар хүний аюулгүй байдлыг хангах, Хүнсний сүлжээний бүх үе шатанд эрсдэлээс урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах замаар хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулах, Аюулгүй орчинд хөдөлмөрлөх, үйлдвэрлэлийн осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөр эрхлэлт болон даатгуулагчдын нийгмийн баталгааг хангуулах, Иргэнийг сурч боловсрох тэгш боломж, чанартай боловсрол эзэмших нөхцөлийг хангуулж, соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилттойгоор 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдөр Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргатай 105 заалт бүхий байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хийж эхний хагас жилийн байдлаар үр дүнг тооцон ажиллаж байна.

Тус хэлтэс нь Монгол Улсын шадар сайдын 2021 оны 1 дүгээр сарын 04-ний өдөр баталсан бүтэц орон тоо батлах тушаалын дагуу 30 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаас Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчийн 1 орон тоо, мал эмнэлгийн хяналтын 2 орон тоо дутуу 27 ажилтан албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Тус дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс нь 27 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр 5225 хүн/өдөр ажиллахаас 68 хүн/өдөр ээлжийн амралттай, 39 хүн/өдөр өвчтэй, нийт 5118 хүн/өдөр ажилласан.

НЭГ: ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

1.1 ТӨЛӨВЛӨГӨӨТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

МХЕГ-ын даргын 2021 оны 05 сарын 14-ны өдрийн 01/1110 тоот албан бичиг. Ногоон түвшин буюу өдөр тутамын бэлэн байдлын үед төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт хийх чиглэлийн дагуу төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамж батлагдаагүй байна.

1.2. ЗӨВЛӨН ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

2021 онд 266 объектод зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр олон нийтэд зарласнаас 1 буюу (0.37%) объектод зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байна. Зөвлөн туслах үйлчилгээний хугацаа болоогүй байна.

1.3 ТАНДАЛТ СУДАЛГААНЫ ТАЛААР

1. МХЕГ-ын дэд даргын баталсан 01/14 дугаартай “Шинээр байгуулагдсан, хаяг байршил өөрчлөгдсөн эрүүл мэндийн болон эм хангамжийн байгууллагын тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагад тандалт судалгаа хийх” удирдамжийн хүрээнд 1 эрүүл мэндийн байгууллага хамрагдсан. Тус эрүүл мэндийн байгууллагууга нь хаяг байршилаа өөрчлөн Сүхбаатар дүүрэгээс үйл ажиллагаа явуулахаар шилжин ирсэн. /Нарны тосгон ХХК/ Уламжлалт анагаах ухааны сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэгчийн хүний нөөцийн хангалт, ажлын байрны нөхцөл байдалд тандалт судалгаа хийх төлөвлөгөөт хяналт шалгалттай уялдуулан хийгдэх тул хийгдээгүй хугацаа хойшилсон.

1.4 ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЛААР

1. Шалгалтанд хамрагдаагүй ус хангамжийн байгууллагуудын ундны усанд хяналт шинжилгээ хийх удирдамжийн хүрээнд ХУД-ийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй 34 хотхон, шинээр ашиглалтанд орж буй 10 барилгын уснаас дээж авч, шинжлүүлэхэд 1 хотхоны ус нянгийн тоо, 2 хотхон нитрат стандартад заасан нормоос их гарч ус хадгалах савыг угаалгаж, халдваргүйжүүлэх арга хэмжээ авсан. Усны дээжинд шинжилгээ хийсэн талаар улсын байцаагчийн нийт 40 дүгнэлт гаргаж хүргүүлсэн.

1.5 УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТЫН ТАЛААР

Эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр:

1. МХЕГ-ын даргын баталсан 2021 оны 02 сарын 18-ны өдрийн 01/45 тоот удирдамжийн хүрээнд: - Давтан тоогоор 238 удаагийн хяналтыг нийт 36 цэгт “Ковид-19” халдварын эсрэг дархлаажуулалтад төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж 1 заалт бүхий 1 албан шаардлага хүргүүлж ажилласан. ХУДЭМТ нь ХӨСҮТ-с 261456 хүн тун вакцин хүлээн авснаас Covishield 20700 хүн тун, Vero cell 237532, Pfizer-Comirnaty 1224, Гам ковид Спутник вакцин 2000 хүн тун вакциныг хүлээн авсан ба вакцины хадгалалтад хяналт тавьж ажилласан. Дархлаажуулалт 2021 оны 02-р сарын 23-ны өдрөөс өдрөөс эхэлж, 06-р сарын 04-ний өдрийг хүртэл хийгдсэн ба дүүргийн хэмжээнд 248073 хүн хамрагдахад тухай бүр хяналт тавьж ажиллалаа.

2. МХЕГ-ын даргын баталсан 01/04 удирдамжийн хүрээнд:- Эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангуулах, эрүүл ахуй халдвар хамгааллын дэглэмийг сахиулах зорилгоор эмчилгээний чанар эрүүл ахуй, халдвар хамгаалал, эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж, эмнэлэгүүд, яаралтай тусламжийн багц, эм эмнэлэгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангуулж, тогтмол хяналт тавьж ажилласан. Шаардлагатай шинжилгээний цэгүүдэд өдрийн турш хуваарийн дагуу хяналт тавин ажилласан. Тус хяналт шалгалтын хүрээнд шинжилгээний цэгүүдэд улсын байцаагчийн зөвлөмжийг хүргүүлж, давтан тоогоор 36 шинжилгээний цэгээр тогтмол хяналт тавьж, хуваарийн дагуу ажлын бүтэн цагаар ажилласан. Мэдээг өдөр бүр болон 3 хоног тутамд удирдамжийн хавсралт хүснэгтэд заасны дагуу НМХГ-ын ЭМБСХХ-т хүргүүлсэн. ХУД-ийн 11, 18, БГД-ийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд

шинжилгээний суурин болон явуулын шинжилгээний 9 цэгт хөндлөнгийн хяналт тавьж ажилласан. Шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг газар дээр нь арилгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

3. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан Коронавируст халдварын дэгдэлтийн үед эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдалд шалгалт хийх тухай удирдамжийн дагуу - Арьсны өвчин судлалын үндэсний төв, Клиникийн нэгдсэн төв эмнэлэг, Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг, Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төв, Багануур дүүргийн нэгдсэн эмнэлэг, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийг хамруулан шалгалтын явцад нийт 95 зөрчил илрүүлж, илэрсэн дутагдлыг арилгуулах зорилгоор 5 эмнэлэгт 45 заалт бүхий улсын байцаагчдын хамтарсан албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч ажилласан. Үүний дагуу албан шаардлагын гүйцэтгэлийн шалгалтыг хийж ажилласан ба биелэлт 90% тай байна.

4. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 01/01, 01/55 тоот удирдамж - Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан эрүүл мэндийн байгууллагуудын коронавируст халдварын үед тусламж үйлчилгээний бэлэн байдал хэрхэн хангагдсан байдалд шалгалт хийх тухай удирдамжийн дагуу 80 эмнэлгийг хамруулав. Шалгалтын явцад нийт 45 зөрчил илрүүлж, 45 буюу 100%-ийг нь газар дээр нь арилгуулж, илэрсэн дутагдлыг арилгуулах зорилгоор мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч 02-01/4677 тоот мэдэгдэл хүргүүлж ажиллалаа. Биелэлт 80% байна.

5. Тайлангийн хугацаанд иргэнээс 5 гомдол ирж ЗТХ-ийн холбогдох заалтын дагуу 3 .800.000 төгрөгөөр торгож, 2 аж ахуй нэгжийн үйл ажиллагааг Прокурорын тогтоолоор түр зогсоож шийдвэрлсэн.

Хүрсэн үр дүн: Хууль сахин мөрдөлтийн түвшин, албан шаардлага, албан даалгаврын биелэлт, торгуулийн барагдуулалт 100% байна.

Эмчилгээний чанарын хяналтын чиглэлээр:

1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан Коронавируст халдварын дэгдэлтийн үед эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдалд шалгалт хийх тухай удирдамжийн дагуу Гэмтэл согог судлалын үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Улаанбаатар төмөр замын төв эмнэлэг, Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, хүүхдийн эмнэлгийг хамруулан шалгалтын явцад нийт 105 зөрчил илрүүлж, 68 буюу 64.8%-ийг нь газар дээр нь арилгуулж, илэрсэн дутагдлыг арилгуулах зорилгоор 5 эмнэлэгт 59 заалт бүхий улсын байцаагчдын хамтарсан албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч ажилласан.

2 .Орон нутаг зорчих иргэдээс Коронавируст халдвар илрүүлэх сорьц авах, түргэвчилсэн оношлуур ашиглан шинжилгээ хийх түр цэгүүдэд тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангуулах, эрүүл ахуй халдвар хамгааллын дэглэмийг сахиулах зорилгоор 1 цэгт 5 удаа хийж, бэлэн байдлыг хангуулж хяналт тавьж ажиллалаа.

3. “Коронавируст халдварын эсрэг вакцин хилээр нэвтрүүлэх болон вакцинжуулалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд 95

удаагийн давтамжтай нийт 25 цэгт хяналт шалгалтыг хийлээ. дархлаажуулалт 2021 оны 02-р сарын 23-ны өдрөөс эхэлж, 6-р сарын 04-ны өдрийг хүртэл ХУДЭМТ нь ХӨСҮТ-с 261456 хүн тун вакцин хүлээн авснаас Covishield 20700 хүн тун, Vero cell 237532 Pfizer-Comirnaty 1224, Гам ковид Спутник вакцин 2000 хүн тун вакциныг хүлээн авсан 248073 хүн хамрагдсан. ДДУХ бүртгэгдээгүй байна.

4. "Коронавируст халдварын дэгдэлтийн үед эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдалд шалгалт хийх тухай" удирдамжийн хүрээнд эмчилгээ, эрүүл ахуй, эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад нийт 86 эмнэлэгт төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийлээ. Хяналт шалгалтаар Нарны тосгон ХХК, CLWH, ХУЭМТ Уран Арт дентал ХХК-д албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч биелэлтийг хангуулан ажиллалаа.

5. "Коронавируст халдварын үед сорьц авах, түргэвчилсэн оношлуур ашиглан шинжилгээ хийх түр цэгүүдэд хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангуулах, эрүүл ахуй халдвар хамгааллын дэглэмийг сахиулах зорилгоор 6 цэгт 34 удаа хийж, бэлэн байдлыг хангуулж хяналт тавьж мөн шинжилгээний цэгүүдэд улсын байцаагчийн зөвлөмжийг хүргүүлж мэдээг тухай бүр өгч ажиллалаа. Илэрсэн зөрчлийг үндэслэн ХУЭМТ улсын байцаагчдын хамтарсан 6 заалт бүхий албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан ажиллалаа.

6. Тусгай зөвшөөрөлгүй эмнэлэг, эмчийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх удирдамжийн хүрээнд иргэн Батцэцэг зөвшөөрөлгүй сэргээн засах үйл ажиллагаа эрхэлсэн тул ЗТХ-ийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг зааснаар зөрчлийн хэрэг нээн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан 300,0 шийтгэлийн арга хэмжээ авч ажиллалаа.

Халдвар судлалын хяналтаар:

1. Орон нутаг зорчих иргэдээс Коронавируст халдвар илрүүлэх сорьц авах, түргэвчилсэн оношлуур ашиглан шинжилгээ хийх түр цэгүүдэд тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангуулах, эрүүл ахуй халдвар хамгааллын дэглэмийг сахиулах зорилгоор 1 цэгт 5 удаа хийж, бэлэн байдлыг хангуулж хяналт тавьж ажиллаа.

6.2. "Коронавируст халдварын эсрэг вакцин хилээр нэвтрүүлэх болон вакцинжуулалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн хүрээнд 95 удаагийн давтамжтай нийт 25 цэгт хяналт шалгалтыг хийлээ. Дархлаажуулалт 2021 оны 02-р сарын 23-ны өдрөөс эхэлж, 6-р сарын 04-ны өдрийг хүртэл ХУДЭМТ нь ХӨСҮТ-с 261456 хүн тун вакцин хүлээн авснаас Covishield 20700 хүнтун, Vero cell 237532 Pfizer-Comirnaty 1224, ГамковидСпутниквакцин 2000 хүн/тун вакциныг хүлээн авсан ба 248073 хүн хамрагдахад хяналт тавьж ажиллалаа . Вакцины дараах урвал бүртгэгдээгүй байна.

6.3. "Коронавируст халдварын дэгдэлтийн үед эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдалд шалгалт хийх тухай" удирдамжийн хүрээнд эмчилгээ, эрүүл ахуй, эм

биобэлдмэлийн хяналтын чиглэлээр улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад нийт 86эмнэлэгт төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийлээ. Хяналт шалгалтаар Нарны тосгон ХХК, CLWH, ХУЭМТ Уран Арт дентал ХХК-д албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч биелэлтийг хангуулан ажиллалаа.

6.4.“Коронавируст халдварын үед сорьц авах, түргэвчилсэн оношлуур ашиглан шинжилгээ хийх түр цэгүүдэд хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангуулах, эрүүл ахуй халдвар хамгааллын дэглэмийг сахиулах зорилгоор 6 цэгт 34 удаа хийж, бэлэн байдлыг хангуулж хяналт тавьж мөн шинжилгээний цэгүүдэд улсын байцаагчийн зөвлөмжийг хүргүүлж мэдээг тухай бүр өгч ажиллалаа. Илэрсэн зөрчлийг үндэслэн ХУЭМТ улсын байцаагчдын хамтарсан 6 заалт бүхий албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан ажиллалаа.

6.5.Тусгай зөвшөөрөлгүй эмнэлэг, эмчийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд иргэн Батцэцэг зөвшөөрөлгүй сэргээн засах үйл ажиллагаа эрхэлсэн тул ЗТХ-ийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг зааснаар зөрчлийн хэрэг нээн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан 300.0 шийтгэлийн арга хэмжээ авч ажиллалаа.

6.6. МХЕГ-ын даргын баталсан“Коронавируст халдварын дэгдэлтийн үед ор дэлгэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдалд шалгалт хийх тухай” 01/95 тоот удирдамжийн хүрээнд Монгол Күвэйтийн төв, Энхсаран, Богд-Уул сувилал, Грандмед, Интермед, ХУД-ийн Нэгдсэн эмнэлэг, Сэргээн засах клиник эмнэлгүүд гэсэн 7 байгууллага шалгалтад хамрагдсан. Шалгалтын дүнг тухай бүр ДОК болон УОК-руу илгээсэн. Одоогийн байдлаар СЗКЭ, ХУД-ийн НЭ-үүд ковид-19 халдварыг эмчлэх ор дэлгэн ажиллаж байна.

Хүнсний эрүүл ахуйн хяналтаар:

Нийтийг хамарсан баяр ёслол, цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх шалгалт хийх- МХЕГ-ын даргын баталсан 01/05 тоот удирдамжийн хүрээнд сар шинийн баярыг угтаж 10 хүнсний худалдааны төвд урьдчилан сэргийлэх шалгалтыг хийж 16 заалт бүхий улсын ахлах байцаагчийн 2 албан шаардлагыг хүргүүлж ажилласан.

Гадаад орны болон төр засгийн тэргүүн, зочин төлөөлөгчдийн айлчлалын үед хоол хүнсний аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх- Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдөр баталсан “Гадаад орны болон төр засгийн тэргүүн, зочин төлөөлөгчдийн айлчлалын үед хоол, хүнсний аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” 01/33 тоот удирдамжийн дагуу Хан-Уул дүүргийн 8 дугаар хороонд байрлах “Вайлд резорт” ХХК-ийн Тайж резорт амралтын газрын үйл ажиллагаанд урьдчилсан сэргийлэх хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчил дутагдалд 12 заалт бүхий улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлж ажилласан.

Тамхи, тамхин бүтээгдэхүүн худалдаалах, сурталчлахад тавигдах шаардлагыг зөрчихөөс урьдчилан сэргийлэх шалгалт хийх- Тайлангийн хугацаанд тамхи худалдаалах тусгай зөвшөөрөлгүй тамхи худалдан борлуулж байсан ХУД-ийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах иргэн Н.Э-д Зөрчлийн тухай хуулийн дагуу 300 нэгжээр торгох, 10800 төгрөгийн хууль бус орлогыг улсын орлого болгож, 27300 төгрөгийн үнэ бүхий утаат тамхийг хураан авч дүүргийн комисст шилжүүлж ажилласан.

Худалдаа үйлчилгээний байгууллага, зах, томоохон худалдааны төвүүдийн эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэмийн мөрдөлт, халдваргүйжүүлэлтэд хяналт тавих- МХЕГ-ын даргын баталсан 01/252 тоот удирдамжийн хүрээнд Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй худалдаа үйлчилгээний 126 газарт голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийх явцад шалгалт хийн ХУД-ийн 1 дүгээр хороонд байрлах Зүчи зочид буудалд илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын ахлах байцаагчийн 3 заалт бүхий албан шаардлага хүргүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/214 тоот тушаал, МХЕГ-ын даргын 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 01/88 тоот “Коронавируст халдварын батлагдсан болон сэжигтэй цогцсыг оршуулах үйл ажиллагаанд хяналт хийх тухай” удирдамж, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/227 тоот захирамжийн дагуу Хан-Уул дүүргийн иргэдийн гэрийн нас баралт 2, эмнэлгийн нас баралт 3, Халдварт өвчин судлалын үндэсний төв, ЭХЭМҮТ-2, Улсын 2 дугаар төв эмнэлэг, Зүүн чандарлах оршуулгын газруудын үйл ажиллагаанд 9 удаа хяналт тавьж ажилласан.

МХЕГ-ын даргын баталсан 01/87 тоот удирдамжийн дагуу ХУД-ийн 13 дугаар хороонд байрлах Нью пакс монголиа ХХК-ийн Монголика тусгаарлан ажиглах байрны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын ахлах байцаагчийн 9 заалт бүхий албан шаардлага хүргүүлж ажилласан.

МХЕГ-ын даргын баталсан 01/04 тоот Коронавируст халдварын үед сорьц авах, шинжилгээ хийх түр цэгүүдэд шалгалт хийх удирдамжийн дагуу Нэг хаалга-нэг шинжилгээ арга хэмжээг хэрэгжүүлэхэд суурин шинжилгээний цэгт 24 удаа, явуулын цэгт 3 удаа, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн явуулын цэгүүдэд 2 өдөр хяналт тавьж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж ажилласан.

МХЕГ-ын даргын баталсан 01/45 тоот Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эсрэг вакциныг хилээр нэвтрүүлэх болон вакцинжуулах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу ХУД-т шинээр нээгдсэн дархлаажуулалтын цэгүүдэд шалгалт хийж, 7 сургууль, 34 дүгээр сургуулиудад хийгдэж буй дархлаажуулалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.

Хүрсэн үр дүн: Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт хүн амыг хоолны хордлого, хордлогот халдварт өвчин гарах, мал амьтнаас хүнд халдварлах халдварт өвчин, гадаад орчны аюулгүй байдлаас үүсэх эрсдэл, аюулаас урьдчилан сэргийлж ажилласан байна.

Хүүхэд өсвөр үеийн хяналтаар:

Боловсрол Шинжлэх Ухааны яамны 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 2/1790 тоот “Тайлан ирүүлэх тухай”, Нийслэлийн Боловсролын газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/21 дүгээр “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалын хүрээнд Хан-Уул дүүргийн Боловсролын хэлтсийн даргын 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/09 дүгээр “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, 2021 оны 05-р сарын 11-12-ны өдрүүдэд дүүргийн 19 хүүхэд харах төвийн баримтлах хууль, журмын хэрэгжилт, орчин нөхцөл байдалд хяналт тавих, санал, дүгнэлт гаргаж, хуваарь, төлөвлөгөөний дагуу ажилласан.

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын 2020 оны 08 сарын 11-ний өдрийн А/321 тоот “Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авах, хугацааг сунгах, хаяг байршлыг өөрчлөх тухай” захирамжын хавсралт 1-д хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл шинээр авах – 7, хавсралт 2-т Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн хугацаа сунгах – 40, хавсралт 3-т хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчдийн хаяг байхшил өөрчлөгдөх -19 тус тус хүүхэд харагчийн зөвшөөрлийг шинэчлэх, сунгах ажил хийгдсэн.

Хүүхэд харах үйлчилгээний байр нь зөвхөн хүүхэд харах үйлчилгээнд зориулагдсан MNS 6540:2015 стандартын 7.1.1 дэх заалтын дагуу байсан. Хаягийн шилжилт хөдөлгөөн хийгдээгүй. Байрны зориулалт өөрчлөгдөөгүй.

Хязгаарлалт тогтоохгүй үйл ажиллагаанд мөрдөх халдвар хамгааллын дэглэмийн байдалд НОК-ын даргын нийтлэг түр зааврын хэрэгжилт, УОК-ын даргын 18 дугаар тушаалаар баталсан коронавируст халдвараас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журмын хэрэгжилтэд дүүргийн 3 дугаар хорооны худалдаа үйлчилгээний 66 объектыг хамруулан өдөр тутмын хяналтыг тавьж заавар, зөвлөмжийг өгч ажилласан.

МХЕГ-ын даргын баталсан 01/04 тоот Коронавируст халдварын үед сорьц авах, шинжилгээ хийх түр цэгүүдэд шалгалт хийх удирдамжийн дагуу Нэг хаалга-нэг шинжилгээ арга хэмжээг хэрэгжүүлэхэд суурин шинжилгээний цэгт 12 удаа, явуулын цэгт 2 удаа, Сүхбаатар дүүргийн суурин шинжилгээний цэгт 1 өдөр хяналт тавьж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж ажилласан.

МХЕГ-ын даргын баталсан 01/45 тоот Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эсрэг вакциныг хилээр нэвтрүүлэх болон вакцинжуулах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу ХУД-ийн ХУЭМТ, 7 дугаар хорооны ӨЭМТ, 7 сургууль, 52 дугаар сургуулиудад хийгдэж буй дархлаажуулалтын үйл ажиллагаанд 6 удаа хяналт тавьж ажилласан байна.

МХЕГ-ын даргын баталсан 01/252 тоот удирдамжийн дагуу халдварын голомтыг цомхотгох, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд 86 объектын 140147 мкв талбайд голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

МХЕГ-ын даргын баталсан 01/87 тоот удирдамжийн дагуу ОБЕГ-ын харьяа 113 дугаар анги, Жаргалант сувилал дах тусгаарлах байранд 3 удаагийн шалгалт хийсэн. Тус тусгаарлах байр нь хоолны цэсийг 7 хоногоор гаргасан боловч гаргасан цэсийн дагуу хоолыг олгоогүй, улаан бүсэд байрлах хамгаалах хувцас өмсөх, тайлах хэсэг нэг өрөөнд байрласан, хэсгийн усан хангамжтай бөгөөд ус нөөцлөх савыг мэргэжлийн байгууллагаар угаалгаж халдваргүйжүүлдэггүй зэрэг зөрчлүүд илэрлээ. Шалгалтын явцад цэвэрлэгээ халдваргүйтгэлд ашиглахаар бэлтгэсэн уусмалд түргэвчилсэн тестээр хлорын идэвхи тодорхойлоход Жавелины уусмал 150 PPM буюу 0.015 хувийн хлорын агууламж зааж байна. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар 4 заалт бүхий албан шаардлага хүргүүлсэн.

МХЕГ-ийн даргын баталсан 01/91 тоот “Коронавируст халдварын батлагдсан болон сэжигтэй цогцсыг оршуулах үйл ажиллагаанд хяналт хийх тухай” удирдамж, ХУД-ийн ЗД-ийн А/227 тоот захирамжийн дагуу Улаанбаатар буян ХХК-ийн Зүүн чандарлах төвд 3 удаа, Эх хүүхдийн эрүүл мэндийн төв-2 эмнэлэгт 3 удаа, ХУД-ийн Нэгдсэн эмнэлэгт 2 удаа Коронавируст халдвараар нас барсан шарилыг шилжүүлэх болон чандарлах үйл ажиллагааны явцад халдвар хамгааллын дэглэм мөрдөлтөд хяналт тавьж ажиллалаа.

Орчны эрүүл ахуйн хяналтаар:

1. Цэвэрлэх байгууламжуудын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг УСУГ-ын морингийн цэвэрлэх байгууламж, Био, Урьдчилан цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн бохир уснаас дээж авч, НМХГ-ын төв лабораторид хими болон нян судлалын шинжилгээ хийлгэхэд “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага” MNS 4943:2015, “Хүрээлэн байгаа орчин. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага” MNS 6561:2015 стандартуудын шаардлагыг хангахгүй байна. Шалгалтад хамрагдсан УСУГ-ын Морингийн даваа, Биогийн цэвэрлэх байгууламжуудийг 2.2 кодтой “Төв болон урьдчилан цэвэрлэх байгууламжийг шалгах хяналтын хуудас”-ны /эрүүл ахуйн хяналтын чиглэлээр/ 20-44 дэх хэсгээр үнэлэхэд 30 хувь буюу тус тус дунд эрсдэлтэй. Урьдчилан цэвэрлэх байгууламжийг 2.2 кодтой “Төв болон урьдчилан цэвэрлэх байгууламжийг шалгах хяналтын хуудас”-ны /эрүүл ахуйн хяналтын чиглэлээр/ 20-44 дэх хэсгээр үнэлэхэд 31.8 хувь буюу дунд эрсдэлтэй үнэлэгдэж улсын байцаагчийн 6 заалт бүхий 3 албан шаардлага хүргүүлсэн. Танилцуулгыг НМХГ-т хүргүүлсэн.

2. ЭМС-ын А/214 тоот тушаал, МХЕГ-ын даргын 01/91 тоот удирдамж, ХУД-ийн Засаг даргын А/227 тоот захирамжийн дагуу оршуулгын үйл ажиллагаа болон чандарлах 7 үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан байна.

3. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангуулахаар 63 ААН-ийн ажлын байрны голомтын халдваргүйтгэл хийх явцад хяналт тавьж ажиллаа.

4. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангуулахаар Зүчи, Ибис зочид буудлуудын тусгаарлах байранд байнгын хяналт шалгалтыг хийж улсын байцаагчийн 1 дүгнэлт, 18 заалт бүхий 2 албан шаардлагыг

хүргүүлж, үйл ажиллагаанд байнгын хяналт шалгалтыг хийж илтгэх хуудсыг НМХГ-т хүргүүлж ажиллаж байна

5. Коронавируст халдвар /Ковид-19/-ын үед сорьц авах, түргэвчилсэн оношлуур ашиглан шинжилгээ хийх 10 түр цэгүүд болон явуулын цэгт байнгын хяналт тавьж ажилласан. БЗД, БГД-ийн шинжилгээний цэгүүдэд дайчлагдан ажилласан.

6. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эсрэг вакциныг хилээр нэвтрүүлэх болон вакцинжуулалтын үйл ажиллагаа Интермэд эмнэлэг, ХУД нэгдсэн эмнэлэгүүдэд Спутник-V, Астразинека вакциныг хүлээж авах явцад хяналт тавьж ажилласан бөгөөд вакцинжуулалтын 10 цэгт байнгын хяналт хийсэн.

7. НАЖГ болон ХУД-ийн Онцгой байдал, Цагдаагийн албатай хамтран амралт, аялал жуулчлалын албатай хамтран 9 ААН-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж, НАЖГ-т илтгэх хуудсыг хүргүүлж ажилласан.

8. УОК, МХЕГ аас өгсөн үүргийн дагуу 11 хорооны гүний худгуудаас шинжилгээ авч дүгнэлт гарган хариуг хүргүүллээ.

Боловсролын хяналтын чиглэлээр:

1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 27 дугаар “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх тухай” тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/86, А/87, А/161 тоот захирамжууд, Улсын онцгой комиссын газрын даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/18 тоот “Коронавируст халварт (ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ын хэрэгжилтийн дагуу урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийлээ. Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж, мэдэгдэл хүргэж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

2. МХЕГ-ын даргын баталсан 2021 оны 05 дугаар сарын 19-ний 01/101 тоот удирдамжийн хүрээнд “Ерөнхий боловсролын сургуулийн давтлага зохион байгуулах үйл ажиллагаанд шалгалт хийх тухай” төлөвлөгөөт бус шалгалт хийлээ. Шалгалтаар БСШУ-ны сайдын “Давтлага зохион байгуулах заавар батлах тухай” 171 дүгээр тушаал, НМХГ-ийн дэд даргын баталсан 02-02/150 дугаар мэдэгдлийн хэрэгжилтийг төрийн болон төрийн бус өмчийн 28 сургуулийг хамруулан хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллалаа.

Энэ хичээлийн жилд 28 сургуулийн 12 дугаар ангийн нийт 1356 сурагч төгсөхөөс 1280 сурагч буюу 94.4 хувь нь давтлагад хамрагдаж байна.

1.1.2 ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

1. Хүнсний үйлдвэрүүдэд хийсэн хяналт шалгалт:

1. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээний үед хүнсний үйлдвэрлэл, худалдаа, хадгалалт, түгээлт, тээвэрлэлт, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд шалгалт хийж, хүнсний аюулгүй байдлыг хангуулах, коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах, хоол

хүнсээр дамжих хордлого, халдвар, болзошгүй эрсдэлээс сэргийлж, зөвлөмж, зөвлөгөө өгөх зорилгоор МХЕГ-ын даргын баталсан 2021 оны 01/05 дугаартай удирдамжийн хүрээнд хоол үйлдвэрлэл үйлчилгээний 11, хүнсний худалдаа, түгээлтийн үйл ажиллагааны 47, үйлдвэрийн 4 нийт 62 объектод хяналт шалгалт хийлээ. Шалгалтын явцад нийт 8 дутагдал илрүүлж буюу 87.5 хувийг нь газар дээр нь богино хугацаанд арилгуулж 1 зөрчлийг хэрэг нээн ЗШША явуулан 1000000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч барагдуулсан.

2. Нийслэлийн Засаг Даргын А/246 тоот захирамж, Улсын онцгой комиссын даргын 18 дугаар тушаалаар батлагдсан Коронавируст халдвар /Ковид 19/-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журамд заасан тусгай нөхцөл, шаардлагыг мөрдөн ажиллаж байгаад хяналт тавих, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2021 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 02-01/792 тоот Чиглэл хүргүүлэх тухай албан бичгийг дүүргийн 10,16 хороодын нийт 24 хэсгийн ахлагчид хүргүүлж, хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан.

3. Улсын онцгой комиссын даргын “Шуурхай зохицуулалтын ажлын хэсэг томилох тухай” тушаал, “Ажлын хэсгийн удирдамж”-ийн хүрээнд Уул уурхай, хүнд үйлвэрийн сайд Г.Ендоноор ахлуулсан ажлын хэсэг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Цагдаагийн Ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын албан тушаалтнуудын бүрэлдэхүүнтэйгээр 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдөр үйл ажиллагааг нь хязгаарлаагүй нийтийн үйлчилгээтэй хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 6 аж ахуй нэгж, иргэний үйл ажиллагаатай танилцаж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөх зөвлөгөө зөвлөмжийг өгч, холбогдох удирдлага, дотоод хяналтын ажилтан, менежер, түрээслэгчдийн төлөөлөл болон тус газруудаар үйлчлүүлж байгаа иргэдийн санал сэтгэгдлийг сонсож, халдвар хамгааллын дэглэмийг хэрэгжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж мэдээлэл өгч ажиллалаа.

2. Худалдааны газруудад хийсэн хяналт шалгалт:

МХЕГ-ын даргын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн баталсан “Хүнсний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх” 01/05 тоот удирдамжийн дагуу тус дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хүнсний худалдааны 150 худалдааны байгууллагад хяналт шалгалт хийхэд 5 иргэний хүнсний мухлагууд нь утаат тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа ЗТХ-ийн 6.3 дугаар зүйлийн 2.4 дах заалтаар 1.500.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, хууль бус орлого 350.0 мянган төгрөг, 38 нэр төрлийн 285 хайрцаг 876300 мянган төгрөгийн утаат тамхийг улсын орлого болгож дүүргийн засаг даргын дэргэдэх зөвлөлд албан тоотоор шилжүүлж, албан даалгавар хүргүүлж ажиллаа. Хяналт шалгалтын явцад 5 аж ахуйн нэгж байгууллагад 5 заалттай улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлж биелэлтийг хангуулан ажиллаж байна. Улсын байцаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй Нар март ХХК-д ЗТХ-ийн 15.2.1.1 дэх заалтаар 500.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

